

Өвөрхангай аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны хөгжлийн 2005 оны гүйцэтгэлийн танилцуулга

Нэг: Нийгэм

Хүн ам

2005 оны эцсээр Өвөрхангай аймгийн суурин хүн ам 108235 болж, үүнээс эрэгтэй 53105, эмэгтэй 55130 хүн байна. Энэ онд 2090 хүүхэд төрж, 633 хүн нас барж, УБ болон бусад аймаг хотруу 1165 хүн шилжиж, 517 хүн шилжиж ирсэн байна. Нийт хүн амын 59.3 хувь нь нь хөдөлмөрийн насны хүн ам, 34.4 хувь нь 16 хүртэлх насны хүүхэд, 6.2 хувь нь 60-аас дээш насны хүн ам эзэлж байна. Хөдөлмөрийн насны хүн амын 71.3 хувь буюу 45.8 мян.хүн ажил хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөр эрхлээгүй 6.7 мян.хүн байгаагийн 2.2 мян.хүн нь хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн байна.

Аймаг 28793 өрхтэй. Үүний 40.4 хувь нь сумын төвд, 59.6 хувь нь хөдөөд оршин сууж байна. Нийт өрхийн 9.0 хувь буюу 2585 нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байна.

Боловсрол

Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын бага, дунд 28 сургуульд 898 багш ажиллаж, 703 бүлэгт 24221 сурагч суралцаж байна. Аймгийн дүнгээр авч үзвэл: 1 бүлэгт 34. сурагч ноогдож байгаа боловч Хужирт, Уянга, Арвайхээр сумын 1.2-р 10 жилийн сургуульд 37-38 хүүхэд ноогдож байгаа нь аймгийн дундаас 3-4-н сурагчаар их байна. Сургуулийн дотуур байрнуудад 3125 хүүхэд амьдарч байна. Сургуулийн өмнөх насны 30 байгууллагад 3488 хүүхэд хүмүүжиж байна.

Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд БОЭТ-1, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг-1, сум дундын эмнэлэг-1, сумын эмнэлэг-16, их эмчийн салбар-2, бага эмчийн салбар /оргүй/-61, эмийн сан-23, ажиллаж эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн байна. Эдгээр эмнэлгүүдэд 600 ор, 170 их эмч, 10 эмийн дээд мэргэжилтэн, 490 эмнэлгийн дунд мэргэжилтэн ажиллаж байна.

2005 онд 2100 эх амаржиж, 0-1 хүртлэх насандаа 52 хүүхэд эндсэн нь урьд оны мөн үеэс 67.7 хувиар өсчээ. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 843 болж урьд оны мөн үеэс 216-аар буурсан байна. Төрөхийн улмаас 2 эх эндсэн байна.

Гэмт хэрэг

2005 онд 458 гэмт хэрэг үйлдэгдсэн нь өмнөх оныхоос 98 хэргээр буурсан байна. Бусдыг санаатай алсан хэрэг 11 гарч өмнөх оныхоос 2-оор буурсан. Нийт гэмт хэргийн дотор иргэдийн өмчийн хулгай 46.5 хувийг эзэлж байна. Хэрэг үйлдэгчдийн тоо 528 байгаагийн 373 нь буюу 70.6 хувь нь 18-35 насны залуучууд байна. Гэмт хэргийн улмаас иргэдэд 271.6 сая, төгрөгийн хохирол учирсан байна.

Хоёр: Эдийн засаг

2005 онд аймгийн татварын албанд албан ёсоор бүртгэлтэй 407 аж ахуйн нэгж байна. Үүнд: ОНӨААҮГ-4, ТӨҮГ-3, ХК-19, ХХК-201, нөхөрлөл-75, хоршоо-105 байна.

Төсөв санхүү

2005 онд аймгийн төсвийн нийт орлого 1376.6 сая. төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 95.8 хувьтай байна. Үүний 3.1 хувийг өөрийн орлого эзэлж байна. Нийт орлогын 25.5 хувь буюу 351.8 сая. төгрөг нь нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татварын шилжүүлгийн орлого байна. Сумдын төсвийн орлогод 1307.1 сая төгрөг орж төлөвлөгөөний биелэлт 96.1 хувьтай байна.

Улсаас орон нутгийн болон төвлөрсөн төсвийн байгууллагын санхүүжилтэнд 7320.6 сая төгрөгийн татаац авсан байна

Төсвийн нийт зарлага 8751.7 сая төгрөг болсны 40.0 хувийг цалин хөлс, 8.2 нийгмийн даатгалын шимтгэл, 1.9 хувийг эрүүл мэндийн даатгал, 46.2 хувийг бараа үйлчилгээ, 2.1 хувийг хөрөнгө оруулалт, их засварын зардал, тус тус санхүүжүүлсэн байна.

Төсөвт газрууд 3.9 сая. төгрөгийн авлагатай, 63.1 сая өглөгтэй гарсан байна.

Аймгийн нийгмийн даатгалын сангуудын орлого 6468.9 сая. төг болж төлөвлөгөө 101.8 хувиар биелэгдсэн байна. Бүх төрлийн тэтгэвэр авдаг 12654 хүнд 5143.2 сая төгрөг,

тэтгэмж авдаг 1539 хүнд 128.6 сая төгрөг олгож, жилд олговол зохих тэтгэвэр тэтгэмжийг 100.0 хувь олгожээ. Нийгмийн халамжийн үйлчилгээгээр 57128 хүнд 2225.9 сая төгрөг зарцуулсан байна. Үүнээс 15011 өрхийн 36013 хүүхдэд 976.1 сая.төгрөгийг олгосон байна.

Арилжааны банкуудын мэдээгээр ХААН, Монгол шуудан, Зоос, Хас банкнаас аж ахуй нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн 19687.5 сая төгрөгт хүрсэн нь урьд оныхоос 3482.3 саяар өсч, хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 37.3 сая төгрөг байна.

Дээрхи банкуудад иргэд, байгууллагуудын хадгалуулсан хадгаламжийн хэмжээ 4413.7 сая төгрөг болж урьд оныхоос 44.4 хувиар нэмэгдсэн байна.

Банкуудын хугацаатай хадгаламжийн хүүний дундаж 1.0-1.5 хувь, хугацаагүй хадгаламжийн хүүний дундаж 0.5-0.8 хувь, зээлийн хүү 3.0-4.5 хувь байна.

Хөдөө аж ахуй

2005 онд 679.1 мянган төл бойжиж, 38.7 мян.мал хорогдож аймгийн мал 2301152 толгой болж өмнөх оноос дүнгээрээ 145700 толгойгоор өссөн байна. Үүнээс тэмээ 13140, адуу 136640, үхэр 99683, хонь 1059446, ямаа 992243 толгой болсон дүн мэдээ гарлаа. Нийт малын 40.3 хувь нь хээлтэгч мал эзэлж байна. Сумдыг малынх нь тоогоор авч үзвэл: Баянгол сум 213682 толгой, Богд 181323 толгой, Сант 177932 толгой, Баян-Өндөр 161828 толгой, Уянга сум 136487 толгой малаар эхний 5 байранд байна. Аймгийн хэмжээгээр мянга түүнээс дээш малтай өрх 47 байна.

Малтай өрх 19672 байгаагийн 1359 нь 10 хүртэл толгой малтай, 2968 өрх 11-30 толгой малтай, 2617 өрх 31-50 толгой малтай, 4756 өрх 51-100 толгой малтай, 4535 өрх 101-200 толгой малтай, 3092 өрх 201-500 толгой малтай, 298 өрх 501-999 толгой малтай, 47 өрх 1000-аас дээш малтай байна. Малтай өрхөөс 1560 өрх авто машинтай, 4341 өрх мотоцикльтай, 68 өрх трактортой, 6196 өрх цахилгаан үүсгэвэртэй, 5654 өрх телевизтэй байна. Малчид энэ онд 24.1 мян.метр эсгий хийжээ.

Аймгийн хэмжээнд 2571.2 га-д үр тариа, 189.8 га-д төмс, 85.0 га-д хүнсний ногоо тариалж, үр тариа 154.5 тн, төмс 1677.1 тн, хүнсний ногоо 910.3 тн-ыг хураан авсан байна. Малчид 19.2 мян.тн байгалийн хадлан, 4.3 мянган тн гар тэжээл бэлтгэжээ.

Үйлдвэрлэл үйлчилгээ

Аж үйлдвэрийн чиглэлийн аж ахуйн нэгж, цэг салбарууд 1698.7 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1710.2 сая.төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

Нийт үйлдвэрлэлтэд хүнснийх 45.7 хувь, цахилгаан дулааных 22.7 хувь, нүүрснийх 20.4 хувь, мод модон эдлэл 3.0 хувь, хэвлэлийнх 0.5 хувь, бусад үйлдвэрлэл 6.4 хувийг тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд энэ онд 1106.9 сая төгрөгийн барилга угсралт их засварын ажил хийсний 61.3 хувь буюу 678.6 сая.төгрөгийн барилга угсралт их засварын ажлыг аймгийн барилга, зам засварын чиглэлийн аж ахуйн нэгжүүд гүйцэтгэсэн байна.

Тээвэр бүхий байгууллага, иргэд нийт 558.1 сая төгрөгний орлоготой ажиллаж өмнөх оны мөн үеэс 27.7 хувиар өссөн байна. 11.4 мян.тн ачаа, давхардсан тоогоор 99.2 мянган зорчигч тээвэрлэлээ.

Холбооны тарифын орлого урьд оны мөн үеэс 49.5 сая төгрөгөөр өсч 641.6 сая төгрөг болсны дотор хүн амаас орсон орлого 1.8 саяар өсч 348.0 сая төгрөгт хүрсэн байна. Өмнөх оны мөн үеэс телефон цэгийн тоо 226-аар нэмэгдэж 3436 болсон байна

Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, цэг салбарууд 2748.8 сая.төгрөгийнбараа борлуулалт хийжээ.

Гурав: Байгаль орчин

Аймаг нийтдээ 6289533.0 га нутаг дэвсгэртэй. Үүний 5767822.9 га нь Хөдөө аж ахуйн газар байдаг. Үүнээс 5716930.7 га-д бэлчээрийн, 5821.8 га-д хадлангийн, 6949.5 га-д тариалангийн, 36981.7 га нь атаршсан талбай эзэлдэг. Нийт талбайн 19011.5 га-нь хот тосгон бусад суурин газар, 9797.1 га-нь зам шунам сүлжээний, 192278 га-нь ойн сан бүхий газар, 297305 га-нь улсын тусгай хэрэгцээний газар тус тус эзэлдэг.

Засаг даргын дэргэдэх статистикийн хэлтэс